



# 2021 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан



# АГУУЛГА

## 01 КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ  
ТУЗ-ын 2021 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан  
ТУЗ-ын гишүүдийн танилцуулга  
Компанийн бүтэц, зохион байгуулалт  
Алсын хараа үнэт зүйл

## 02 БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2021 оны хагас жилийн үйл ажиллагааны товч тайлан  
2021 оны төлөвлөгөө, зорилго зорилтууд

## 03 САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

i tools

# КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ





## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

**Б.Тамир**  
Гүйцэтгэх захирал

Эрхэм хүндэт хөрөнгө оруулагчид, харилцагчид, түнш байгууллагууд болон бүтээлч хамт олондоо энэ өдрийн мэнд хүргэе. 2021 он гарснаар хагас жилийн хугацаа өнгөрч бид та бүхэнд санхүүгийн болон үйл ажиллагааныхаа тайлан мэдээг хүргэж байна.

Энэ хагас жилд улсын хэмжээнд цар тахлын тархалт хурдацтай нэмэгдсэн нь үндэсний үйлдвэрлэгч компанийн хувьд маш том сорилт байлаа. Гэсэн хэдий ч Айтүүлс ХК нь 2-р улирлын байдлаар 62,9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа. Энэхүү үзүүлэлт нь сүүлийн 3 жилд байгаагүй өндөр дүн бөгөөд өмнөх жилийн мөн үеэс 176%-аар өссөн үзүүлэлт юм.

Бид тайлант үед Дархан хотод байрлах модулар дата төвийн үйл ажиллагаагаа эхлүүлэх, Үндэсний үүлэн технологийн дэд бүтцийн өргөтгөл хийх төлөвлөгөөтэй байсан ч цаг үеийн нөхцөл байдал, олон удаагийн хатуу хорио, цээрийн арга хэмжээнээс хамаарч хугацаа хойшиллоо.

Гэвч бид 10 жилийн ойгоо тохиолдуулан зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийг шат дараатай нэвтрүүлж байгаа нь харилцагч, хэрэглэгчдийн талархлыг хүлээгээд байна.

Хагас жилийн төгсгөлд компанийн хувьцааны ханш 119.2 төгрөгт хүрсэн нь та бүхний бидэнд хүлээлгэж байгаа итгэлийн илэрхийлэл гэж үзэж байна.

Цаашид та бүхний хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх, компанийн сайн засаглалыг тогтворжуулах, үйл ажиллагаагаа өргөжүүлэх, олон улсын түвшинд гарч ажиллахаа илэрхийлж байна.

## ТУЗ-ЫН 2021 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Айтүүлс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Монгол улсын Компанийн тухай хуульд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага бөгөөд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах, чиглүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлдэг.

ТУЗ-өөс жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг хянан, холбогдох үүрэг, чиглэлүүдийг өгч ажиллаж байна. Мөн ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулан компанийн засаглалыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үүнд:


- Аудитын хороо
- Нэр дэвшүүлэх хороо
- Цалин урамшууллын хороо
- Мэдээллийн аюулгүй байдлын хороо
- Бизнес хөгжлийн хороо

“Айтүүлс” ХК нь Мэдээлэл технологийн компани учир өөрийн компанийн онцлогт нийцүүлэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх “Мэдээллийн аюулгүй байдлын хороо” болон Бизнес хөгжлийн хороог байгуулан Гүйцэтгэх удирдлагын багт дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

2021 оны эхний хагас жилд ТУЗ нь ээлжит болон ээлжит бус хурлаа танхимаар, эчнээгээр болон цахим хэлбэрээр цаг алдалгүй нийт 7 удаа зохион байгуулж, “Айтүүлс” ХК-ийн үйл ажиллагаанд шаардлагатай хуульд заасан асуудлаар тогтоол гарган, компанийн стратегийг тодорхойлж, үйл ажиллагааг чиглүүлэн, хяналт тавьж ажиллалаа.



# КОМПАНИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



## ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН



**Г.Хатанболд**

ТУЗ-ийн дарга

- Санхүүгийн удирдлагын магистр
- Ай Си Ти Групп ХК-ийн Гүйцэтгэх захирал



**З.Мягмарсүрэн**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

- Зах зээл судлаач, эдийн засагч
- Бодь тусгал Аудит ХХК-ийн захирал
- Аудитын хорооны дарга



**Г.Гантуяа**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

- Бизнесийн удирдлагын докторант
- Бизнесийн удирдлагын магистр
- Номадик контент ХХК-ийн үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал
- Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны дарга
- Мэдээллийн аюулгүй байдал, Бизнес хөгжлийн хорооны гишүүн



**Н.Жавхлан**

ТУЗ-ийн хараат бус гишүүн

- Төрийн удирдлагын магистр
- Могул Консалтинг сервис ХХК-ийн Гүйцэтгэх захирал
- Бизнес хөгжлийн хорооны дарга
- Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, нэр дэвшүүлэх хороо болон Мэдээллийн аюулгүй байдлын хорооны гишүүн



**А.Баттамир**

ТУЗ-ийн ердийн гишүүн

- Техникийн ухааны докторант
- Техникийн ухааны магистр
- Ай Си Ти Групп ХК-ийн үүсгэн байгуулагч, Дэд захирал
- Мэдээллийн аюулгүй байдлын хорооны дарга
- Бизнес хөгжлийн хорооны гишүүн



**Н.Улаанхүү**

ТУЗ-ийн ердийн гишүүн

- Эдийн засгийн онолч, эдийн засагч
- Цалин урамшууллын хорооны гишүүн



**Б.Эрдэнэжаргал**

ТУЗ-ийн ердийн гишүүн

- Бизнесийн удирдлагын бакалавр
- Стандарт инвестмент ҮЦК-ийн диллер



**Б.Тамир**

ТУЗ-ийн ердийн гишүүн

- Улс төрийн удирдлагын магистр
- Айтүүлс ХК-ийн Гүйцэтгэх захирал
- Бизнес хөгжлийн хорооны гишүүн



**Б.Амгаланбаатар**

ТУЗ-ийн ердийн гишүүн

- Нягтлан бодогч
- Ай Си Ти Групп ХК-ийн Санхүү, удирдлагын газрын захирал
- Аудитын хороо, Цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хорооны гишүүн



**Г.Янжинлхам**

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

- Нийтийн удирдлага магистр, эрх зүйч

### Хувьцаа эзэмшигч:

ICT group JSC	39.6%
AFC Umbrella fund – AFC	13.6%
Standard Investment	10.3%
Олон нийт	36.3%

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдах /үйлчилгээ үзүүлэх/ замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг ханган ажиллах

## АЛСЫН ХАРАА

Дэлхийн жишиг дата төв болж, бүтээгдэхүүн үйлчилгээгээ дэлхийд экспортолно

## ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛ

Компани төдийгүй эх орныхоо төлөө бие сэтгэл, мэдлэг чадвараа бүрэн дайчлан ажиллаж буй бизнесийн ёс зүйтэй баг хамт олон

Мэдээллийн технологийн үнэ цэнийг ойлгож үргэлж хамт байдаг хэрэглэгч, харилцагч, бизнесийн түншүүд

Дэлхийд чанараар өрсөлдөх бүтээгдэхүүн, үйлчилгээ

Харилцагчийн мэдээллийн аюулгүй байдал

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

Ёс суртахуунтай, ил тод, нээлттэй  
Хууль, эрх зүйн хэм хэмжээг дээдэлнэ  
Мэдээллийн аюулгүй байдлыг чандлан сахина

## УРИА ҮГ

Зогсолтгүй хөгжиж, амжилтаараа ялгаръя



i tools

# БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



## 2021 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

“Айтүүлс” ХК-ийн эрхэм зорилго нь Монгол улсын эдийн засаг, мэдээллийн технологийн салбарт хувь нэмрээ оруулж, чанартай, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээгээр баялаг бүтээхийн зэрэгцээ, олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд компанийн зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлж, хувьцаа эзэмшигчдэд үнэ цэн хүртээх явдал билээ.

Энэ зорилгын хүрээнд бид 2021 оны эхний хагас жилд Айтүүлс брэндийн нүүр царайг шинэчлэн тодорхойлж, дараагийн 10 жилийн хөгжлийн зүг чигээ улам бататгалаа.

2021 онд бид мэдээллийн технологийн дэд бүтэц болох дата төвийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх, үүлэн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ нэмэгдүүлэх, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлж хэрэглэгчдэд хүргэх, дэд бүтэцэ сайжруулан, тасралтгүй найдвартай ажиллаж, харилцагчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх, хувьцаа эзэмшигчдээ мэдээллээр ханган ажиллах зорилтуудыг тавин ажиллаж байгаа билээ.

### ҮҮЛЭН ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ БОЛОН ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ ХӨГЖҮҮЛЭЛТ

#### ICS үйлчилгээ

“Фибо Глобал” ХХК-тай хамтран хөгжүүлсэн үндэсний үүлэн технологийн ICS үйлчилгээ маань өргөжин тэлж, борлуулалтын орлого маань 2021 оны бизнес төлөвлөгөөнөөс 28%-иар, өмнөх оны мөн үеэс 2400%-иар өссөн байна. 2021 оны эхний хагас жилд хүчин чадлыг өргөтгөх, хэрэглэгчдийн интерфэйс, back-office-ын хэсгийг сайжруулах, тайлан, dashboard-ыг илүү боловсронгуй болгох гэх мэт хөгжүүлэлтийн ажлууд хийгдлээ.

#### Үндэсний үүлэн технологийн платформ – CLOUD.MN

Бид олон жилийн туршлага, хүний нөөц болон дэд бүтэц дээрээ тулгуурлан үндэсний үүлэн технологийн платформ CLOUD.MN-ыг 2021 онд багтаан ашиглалтанд оруулж, хэрэглэгчдэд хүргэхтэй холбоотойгоор дэд бүтцийн өргөтгөл, хөгжүүлэлтийн ажлуудыг хийж байна. CLOUD.MN платформ нь цахим шилжилтийн хэрэгцээ шаардлага өдөр өдрөөр нэмэгдэж буй өнөө үед уламжлалт болон гарааны бизнесүүд, технологийн компаниуд, төр болон хувийн хэвшлийн байгууллага, компаниудад технологийн шийдлүүд, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээ зах зээлд гаргах боломжийг олгож, хэрэглэгчдэд эдгээр үйлчилгээнүүдийг нэг дороос авах, худалдан авсан бүтээгдэхүүн үйлчилгээгээ мэргэжлийн найдвартай багт даатган, цогц үйлчилгээ хүртэх боломжийг олгох юм.

#### Сургалтын менежментийн систем

2020 онд үүлэн технологи дээр суурилсан сургалтын менежментийн системийг БШУЯ-тай хамтран хөгжүүлж 30 орчим сургууль дээр туршин нэвтрүүлсэн бөгөөд 2021 оны эхний хагас жилд энэхүү үйлчилгээг өргөжүүлэх, хот хөдөөгийн ЕБС-иудад нэвтрүүлэх ажлын хүрээнд сервер, тоног төхөөрөмжийн худалдан авалт, өргөтгөл хийх, хөгжүүлэлт сайжруулалт хийх ажлыг 2021 оны эхний хагас жилд “Фибо Глобал” ХХК-тай хамтран үргэлжлүүлэн гүйцэтгэж байгаа бөгөөд хичээлийн шинэ жилд эхний ээлжинд 100-аад сургуульд нэвтрүүлэхээр ажиллаж байна.

#### Webdy – Вэбдий үйлчилгээ

2021 оны эхний хагаст бид хялбар вэбсайт угсрах хостинг, вэб угсралт хавсарсан үйлчилгээг шинээр амжилттай нэвтрүүллээ. Үнэтэй график дизайнер, вэбсайт бүтээдэг байгууллагаар вэбсайтаа хийлгэх боломжгүй, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч байгууллага, хувь хүмүүст зориулан бизнесийн төрөл, чиглэлдээ нийцсэн загваруудаас сонголт хийн, богино хугацаанд өөрөө угсрах боломжтой хялбар вэб угсралтын үйлчилгээг вэб байршуулах үйлчилгээний хамт гарган, дэд бүтцийн асуудлыг шийдэн амжилттай ажиллаж байна.

## ХЭРЭГЛЭГЧИЙН СИСТЕМИЙГ САЙЖРУУЛАХ ХАРИЛЦАГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

- Манай байгууллагын хэрэглэгч харилцагчийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа бөгөөд 2019 онд 6,957 хэрэглэгч, 2020 он 9,140 хэрэглэгчтэй байсан бол 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт бүртгэлтэй хэрэглэгч 10,266 хүрсэн байна. 2020 он эцсийн байдлаар бүртгэлтэй хэрэглэгчийн 39% нь идэвхтэй хэрэглэгч байсан бол 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт хэрэглэгчийн 45% нь идэвхтэйгээр бүтээгдэхүүн үйлчилгээ захиалан ашиглаж байна. Ийнхүү 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 15,648 бүтээгдэхүүн үйлчилгээг 4266 хэрэглэгчид хүргэн ажилласан байна.
- 2021 оны эхний хагас жилийн байдлаар технологи төлөвлөлт, үйл ажиллагааны хэлтэст нийт 6211 дуудлага буюу хуанлийн өдөр бүр дунджаар 35 дуудлага ирсэн бөгөөд 98%-ийн амжилттайгаар асуудлыг шийдэж ажилласан байна. Мөн гаднаас ирсэн дуудлагаас гадна технологи төлөвлөлт, үйл ажиллагааны хэлтсээс эхний хагас жилд 350 outbound дуудлага үйлдэн, авч буй бүтээгдэхүүн үйлчилгээний талаар санал гомдол байгаа эсэх, шийдвэрлэх асуудал байгаа эсэхийг тодруулан, хэрэглэгчээ халамжлан ажилласан байна.
- Мөн хэрэглэгчийн системийн шинэчлэлт, Үндэсний дата төвийн ДАН системтэй холбох, төлбөрийн сувгийг өргөтгөх ажлуудыг холбогдох байгууллагуудтай хамтран шат дараатайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлбөрийн сувгийг өргөтгөх ажлын хүрээнд 2021 оны эхний хагаст системийн судалгаа, дэд бүтцийн орчинг үүсгэж, тохируулгыг хийсэн бөгөөд төлбөрийн прау болон socialpay системүүдийг 2021 онд нэвтрүүлэх хөгжүүлэлтийн ажил хийгдэж байна. Хэрэглэгчийн системийг сайжруулснаар, компанийн мэдээллийн уялдаа холбоог сайжруулах, тусламж үзүүлэх хугацааг богиносгох, хэрэглэгчдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх болно.

## ДЭД БҮТЦИЙН ӨРГӨТГӨЛ, САЙЖРУУЛАЛТ

- Энэхүү зорилтын хүрээнд УБ хотын дата төв болон санхүүгийн дата төвийн дэд бүтцийн сайжруулалт шинэчлэлтийн ажлуудыг шат дараатайгаар хийж гүйцэтгэж байна. Үүнд шинээр сервер тоног төхөөрөмж худалдан авч, хүчин чадлыг өргөтгөх, цахилгааны болон сүлжээний кабелиуд, самбаруудыг шинэчлэх ажлууд хийгдэж, дата төвийн cold containment, өргөлттэй шалны засвар үйлчилгээг хийж, хөргөлтийн тоног төхөөрөмж худалдан авалт суурилуулалт зэрэг ажлууд хийгдлээ.
- Ингэснээр 2021 оны эхний хагас жилийн байдлаар дата төв дээр цахилгаан, сүлжээ болон бусад хүчин зүйлстэй холбоотой "Айтүүлс" ХК-иас үүдсэн ямар нэгэн урт хугацааны тасалдал гараагүй бөгөөд дата төвийн uptime үзүүлэлт 99.997%, downtime 0.003% байсан байна.

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

- Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн талаарх үнэн зөв мэдээллээр хувьцаа эзэмшигчдийг тогтмол хангаж байх нь оролцогч талуудаас хамаарч үүсэх эрсдлийг бууруулах, илтгэлцлийг бататгах, тэдний өмнө хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх гэх мэт ач холбогдолтой билээ. Бид санхүүгийн тайлан мэдээ, ТУЗ-ын хурлаас гарсан тогтоол шийдвэр, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа зэрэг баримт бичгүүдийг цаг тухай бүрт нь холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллалаа.
- Хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангах ажлын хүрээнд бид улирал бүр санхүүгийн тайлан ба тайлангийн шинжилгээ хийн ажиллаж байгаа ба 2021 оны эхний улирлын санхүүгийн тайланг клубхаус платформоор дамжуулан сонирхогч талуудад хүргэлээ. Мөн 2021 оны 2-р улирлын санхүүгийн тайлангаа Монголын хөрөнгийн биржийн фэйсбүүк хуудсаар дамжуулан шууд хүргэлээ.
- Сүүлийн жилүүдэд манай компани үйлчилгээний нэр төрлөө нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн, үүнтэй холбоотой хөрөнгө оруулалтууд хийгдэж байгаа ба санхүүгийн хувьд эрүүл, тогтвортой бүтэцтэй, ил тод нээлттэй ажиллахыг эрхэмлэж ирсэн болно.
- 2021 оны Бизнес төлөвлөгөөний дагуу энэ оны эхний хагас жилд Дарханы дата төвийг ашиглалтанд оруулах төлөвлөгөөтэй байсан ч цаг үеийн нөхцөл байдал, хорио цээрийн дэглэм, хөдөө орон нутаг руу нэвтрэхтэй холбоотой хүндрэлүүд, хил гаалийн нөхцөл байдлаас үүдэн энэхүү ажил маань хойшилсон ч 2021 оны 10 сард дуусгахаар чармайн ажиллаж байна.

## 2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ ЗОРИЛГО ЗОРИЛТУУД

### Зорилго

“Айтүүлс” ХК-ийн үйл ажиллагааны гол зорилго нь Монгол улсын эдийн засаг, мэдээллийг технологийн салбарт хувь нэмрээ оруулж, чанартай, шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээгээр баялаг бүтээхийн зэрэгцээ, олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд компанийн зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлж, хувьцаа эзэмшигчдэд үнэ цэн хүртээх явдал юм. Энэхүү гол зорилтынхоо хүрээнд бид 2021 оны үйл ажиллагаандаа бид дараах зорилтуудыг тавьж ажиллаж байна.

Үүнд:

- Хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх
- Борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх
- Харилцагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх

### Зорилтууд

Дээр дурдсан гурван зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн, эдгээр зорилтуудыг дэвшүүлэн, эдгээр зорилтуудын дагуу авах арга хэмжээний богино хугацааны бизнес төлөвлөгөөг боловсруулж ТУЗ-ын тогтоолоор батлууллаа.

Үүнд:

#### 1. Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэл, нэвтрүүлэлт

2021 онд “Айтүүлс” ХК-с шинээр хэд хэдэн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, өргөтгөх зорилт тавьсан ба үүнд, веб сайт хялбар угсралтын үйлчилгээ, вордпресс (wordpress) хостинг үйлчилгээ, масс и-мэйлийн үйлчилгээг хөгжүүлэн, хэрэглэгчдэд хүргэхээр төлөвлөв. Мөн “Фибо Клауд” ХХК-тай хамтран “Үүлэнхүү” үндэсний үүлэн технологийн платформын хүчин чадлыг өргөтгөх, “LMS” сургалтын удирдлагын цогц системийн сайжруулалт, хөгжүүлэлтийн ажлыг хийхээр төлөвлөв.

#### 2. Дархан хот дахь дата төвийг ашиглалтад оруулах

Дархан хот дахь дата төвийг ашиглалтад оруулах нь “Айтүүлс” ХК-ийн хувьд хувьцаа эзэмшигчдийн итгэл үнэмшлийг бататгах, цаашдын үйл ажиллагааг өргөжүүлэн, илүү найдвартай, аюулгүй болгох, олон улсын дата төвийн чанар стандартад нийцсэн үйлчилгээг харилцагчиддаа үзүүлэх талаас ач холбогдлын зэрэг өндөртэй зорилт юм. Тиймээс энэхүү ажлыг төлөвлөх, гүйцэтгэх тал дээр онцгой анхаарч ажиллах бөгөөд компанийн зүгээс шаардагдах хөрөнгө оруулалтыг цаг алдалгүй хийж, товлосон хугацаанд гүйцэтгэж, ашиглалтанд оруулах төлөвлөгөөтэй байна. Энэхүү төслийн хөрөнгө оруулалтыг компанийн өөрийн хөрөнгөөр болон зээлийн эх үүсвэрээр шийдэхээр төлөвлөсөн.

#### 3. Дэд бүтэц, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх

Энэхүү зорилтын хүрээнд, хэрэглэгчдэд хүргэж буй бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах үүднээс УБ дахь дата төв болон санхүүгийн дата төвийн дэд бүтэц, тоног төхөөрөмжийг сайжруулан, өргөтгөл, шинэчлэлт хийх ажлуудыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөв.

#### 4. Харилцагч, хэрэглэгчийг сургах, халамжлах

Харилцагчдын дийлэнх гомдол санал нь зарим бүтээгдэхүүн үйлчилгээ бүрэн автоматжуулагдаагүйтэй холбоотой байна. Иймд бүх бүтээгдэхүүн үйлчилгээг автоматжуулах ажлууд хийхээр төлөвлөж байна. Мөн потенциал үйлчлүүлэгч бүрийг хэрэглэгч болгох, түүнчлэн хэрэглэгчийн асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгааг үнэлэх, дүгнэх, гомдол саналыг мөн чанар, шалтгааныг тодорхойлох үүднээс CRM системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.

Клауд үйлчилгээ нь Монголын зах зээлд шинээр нэвтэрч буй үйлчилгээ тул хэрэглэгчдийг сургах зайлшгүй шаардлага үүсч байна. Цаашид тус үйлчилгээний хэрэглэгчдийг үе шаттайгаар сургах, мэдлэгийг тэлэх зорилгыг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгав.

#### 5. Хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангах

Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн талаарх үнэн зөв мэдээллээр хувьцаа эзэмшигчдийг тогтмол хангаж байх нь оролцогч талуудаас хамаарч үүсэх эрсдлийг бууруулах, илтгэлцлийг бататгах, тэдний өмнө хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх гэх мэт ач холбогдолтой тул 2021 оноос улирлын тайлангуудыг боловсуулахын зэрэгцээ эдгээр тайлангуудад шинжилгээ хийж хувьцаа эзэмшигчдэд хүргэх төлөвлөгөөтэй байна. Энэ нь компанийн санхүүгийн үзүүлэлтүүдийг тогтмол хугацаанд хянаж байх, харьцуулалт хийж зүй тогтлыг олж тогтоох, шаардлага хангахгүй үзүүлэлтийг эрт илрүүлэх, үүний дагуу шаардлагатай арга хэмжээг хэлэлцэх, цаашид компанийн санхүү, олон улсын НБББББ-ын стандарт, сахилга батыг дээшлүүлэхэд чухал нөлөөтэй гэж үзэж байна.

# САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



## САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Үзүүлэлт	2019 Q2	2020 Q2	2021 Q2
<b>ХӨРӨНГӨ</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	61,335,780	52,254,187	94,248,390
Дансны авлага	151,203,473	435,563,951	708,096,499
Татвар, НДШ-ийн авлага	-	271,267	591,276
Бусад авлага	412,396,300	43,724,098	1,404,513
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-	-
Бараа материал	97,057,072	100,885,275	100,526,228
Урьдчилж төлсөн зардал тооцоо	238,585,512	182,073,098	673,367,564
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-	-
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>960,578,136</b>	<b>814,771,876</b>	<b>1,578,234,469</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө	2,452,528,703	1,432,241,719	1,759,391,632
Биет бус хөрөнгө	132,249,431	110,308,379	75,673,656
Биологийн хөрөнгө	-	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	70,446,145	70,446,145	70,446,145
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-	-
Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	1,008,172,180	1,008,172,180
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,655,224,279</b>	<b>2,621,168,423</b>	<b>2,913,683,613</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,615,802,415</b>	<b>3,435,940,298</b>	<b>4,491,918,082</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>			
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
Дансны өглөг	110,754,102	57,304,841	26,334,801
Цалингийн өглөг	446,250	5,552,758	34,056
Татварын өр	30,733,429	50,231,209	63,229,356
НДШ-ийн өглөг	20,750,565	-	-
Богино хугацаат зээл	-	-	-
Хүүний өглөг	-	-	-
Ногдол ашгийн өглөг	-	-	-
Урьдчилж орсон орлого	303,755,524	87,699,704	-
Нөөц / өр төлбөр /	-	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	112,903,493	-	-
"Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)- нд хамаарах өр төлбөр"	-	-	-
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>579,343,364</b>	<b>200,788,512</b>	<b>89,598,213</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>			
Урт хугацаат зээл	-	-	877,000,000
Нөөц / өр төлбөр /	-	-	-
Хойшлогдсон татварын өр	-	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-	-
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>877,000,000</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>579,343,364</b>	<b>200,788,512</b>	<b>966,598,213</b>
<b>Эздийн өмч</b>			
Төрийн өмч	-	-	-
Хувийн өмч	905,758,223	1,481,441,363	1,481,441,363
Хувьцаат өр төлбөр	1,338,798,000	-	-
Халаасны хувьцаа	-	-	-
Нэмж төлөгдсөн капитал	763,114,860	763,114,860	763,114,860
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	460,721,652	460,721,652	460,721,652
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-	-
Хуримтлагдсан ашиг	331,181,176	529,873,911	820,041,993
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>3,036,459,051</b>	<b>3,235,151,786</b>	<b>3,525,319,868</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>3,615,802,415</b>	<b>3,435,940,298</b>	<b>4,491,918,082</b>

## ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Үзүүлэлт	2019 Q2	2020 Q2	2021 Q2
Борлуулалтын орлого (цэвэр)	1,098,392,545	1,401,043,015	924,104,631
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	648,298,093	1,028,321,425	468,751,441
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>450,094,452</b>	<b>372,721,590</b>	<b>455,353,190</b>
Түрээсийн орлого	5,454,545	13,636,364	15,227,273
Хүүгийн орлого	395,547	395,547	-
Ногдол ашгийн орлого	-	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-	-
Бусад орлого	36,283,497	2,776,676	-
Борлуулалт, маркетингийн зардал	-	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	442,879,330	321,037,551	401,511,079
Санхүүгийн зардал	-	-	-
Бусад зардал	2,160,000	21,882,343	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	2,397,949	237,629	899,289
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(4,301,600)	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-	-
Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	(1,911,441)	-	-
Бусад ашиг (алдагдал)	-	-	-
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>47,675,219</b>	<b>42,442,559</b>	<b>69,968,672</b>
Орлогын татварын зардал	4,767,522	6,872,884	6,996,867
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>42,907,697</b>	<b>35,569,675</b>	<b>62,971,805</b>
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-	-
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>42,907,697</b>	<b>35,569,675</b>	<b>62,971,805</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
Бусад олз (гарз)	-	-	-
<b>Орлогын нийт дүн</b>	<b>42,907,697</b>	<b>35,569,675</b>	<b>62,971,805</b>
Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	1.25	1.03	1.83

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

No	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж тологдсон капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн ноц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,481,441,363	-	763,114,860	460,721,652	-	-	494,304,235	3,199,582,111
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	1,481,441,363	-	763,114,860	460,721,652	-	-	494,304,235	3,199,582,111
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	-	-
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	-
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	262,765,953	262,765,953
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-	-
9	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,481,441,363	-	763,114,860	460,721,652	-	-	757,070,188	3,462,348,064
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	1,481,441,363	-	763,114,860	460,721,652	-	-	757,070,188	3,462,348,064
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	-	-
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-	-
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	62,971,805	62,971,805
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-	-
17	2021 оны 6-р сарын 30-ны үлдэгдэл	1,481,441,363	-	763,114,860	460,721,652	-	-	820,041,933	3,525,319,808

## МӨНГӨН УРСГАЛЫН ТАЙЛАН

Үзүүлэлт	2019 Q2	2020 Q2	2021 Q2
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,543,970,643</b>	<b>1,285,464,120</b>	<b>943,703,072</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	1,202,527,388	1,282,736,847	933,930,345
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-	-
Буцаан авсан албан татвар	-	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-	-
Бусад мөнгөн орлого	341,443,255	2,727,273	9,772,727
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>1,447,282,961</b>	<b>1,358,700,130</b>	<b>812,266,903</b>
Ажиллагсад төлсөн	143,334,770	121,909,943	187,727,648
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	23,778,558	19,785,844	45,634,518
Бараа материал худалдан авахад төлсөн	695,718,234	1,004,494,579	2,197,400
Лицензийн төлбөрт төлсөн	-	-	314,671,093
Түрээсийн төлбөрт төлсөн	-	-	-
Ашиглалтын зардалд төлсөн	107,930,695	1,643,791	52,353,540
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,025,490	-	45,743,956
Хүүний төлбөрт төлсөн	-	-	-
Татварын байгууллагад төлсөн	306,093,551	101,667,715	54,710,882
Даатгалын төлбөрт төлсөн	-	-	-
Бусад мөнгөн зарлага	166,401,663	109,198,258	109,227,867
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>96,687,682</b>	<b>(73,236,010)</b>	<b>131,436,170</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>77,600,992</b>	<b>1,049,080,562</b>	<b>68,726,365</b>
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-	-
Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	-	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	-	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө боруулсаны орлого	-	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	77,143,520	1,048,450,951	68,726,365
Хүлээн авсан хүүний орлого	457,473	629,611	-
Хүлээн авсан ногдол ашиг	-	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>287,296,931</b>	<b>452,050,141</b>	<b>1,141,163,005</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	209,152,122	-	454,744,899
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	78,144,809	452,050,141	686,418,106
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(209,695,938)</b>	<b>597,030,421</b>	<b>(1,072,436,640)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>321,196,979</b>	<b>111,780,473</b>	<b>877,973,038</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	321,196,979	110,560,856	877,000,000
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-	-
Төрөл бүрийн хандив	-	-	-
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	-	1,219,617	973,038
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>178,290,963</b>	<b>657,869,757</b>	<b>17,595,657</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	178,290,963	657,724,164	17,521,793
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-	-
Хувьцаа буцаан худалдаж төлсөн	-	-	-
Төлсөн ногдол ашиг	-	-	-
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	-	145,593	73,863
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>142,906,016</b>	<b>(546,089,283)</b>	<b>860,377,382</b>
<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>2,674,177</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>32,571,937</b>	<b>(22,294,872)</b>	<b>(80,623,089)</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>28,763,843</b>	<b>74,549,060</b>	<b>174,871,479</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>61,335,780</b>	<b>52,254,187</b>	<b>94,248,390</b>



## БАЛАНС



2021 оны эхний хагас жилийн байдлаар компанийн нийт хөрөнгийн хэмжээ 4.49 тэрбум төгрөг болж өссөн бөгөөд энэ нь 2021 оны бизнес төлөвлөгөөний дагуу авсан зээл болон уг зээлээр хийгдсэн хөрөнгө оруулалтаас үүдсэн байна. 2021 он хүртэл "Айтүүлс" ХК нь үйл ажиллагаагаа ихэвчлэн эздийн өмчөөр санхүүжүүлж ирсэн ба урт хугацаат зээлгүйгээр ажиллаж ирсэн. 2021 онд үндэсний үүлэн технологийн платформыг хөгжүүлэх, ICS, сургалтын менежментийн системийг өргөтгөх, Дархан дата төвийг ашиглалтанд оруулах зорилтуудын хүрээнд, ХЭХ-ын шийдвэрийн дагуу урт хугацаат зээл авсан билээ.

Өр төлбөр эздийн өмчийн хувьд дээр дурдсанчлан 2021 оны бизнес төлөвлөгөөний дагуу урт хугацаат зээлийг авч хөрөнгө оруулалтуудыг шат дараатайгаар хийж байна. Дараах графикуудаас компанийн үйл ажиллагааг санхүүжүүлж буй бүрэлдэхүүн хэсгүүдийн хувь хэмжээ хэрхэн өөрчлөгдсөнийг, мөн нийт хөрөнгө болон өр төлбөр, эздийн өмчийн бүтэц, хэмжээ 3 жилийн мөн үеүдтэй харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөнийг харж болно.

**Компанийн хөрөнгийн бүтэц буюу нийт хөрөнгийн хэдэн хувийг эздийн өмч, өр төлбөрөөр санхүүжүүлж ирснийг 3 жилээр харьцуулсан харьцуулалт**



**Нийт хөрөнгө ба өр төлбөр, эздийн өмчийн бүтцийг 3 жилээр харьцуулсан харьцуулалт**



## ОРЛОГЫН ТАЙЛАН


2021 оны эхний хагас жилийн хувьд борлуулалтын орлого 34%-иар буурсан, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 54%-иар буурсан байна. Харин үйл ажиллагааны зардал өмнөх оны мөн үеийнхээс 25%-иар өссөн ч цэвэр ашиг 176%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Үндсэн үйл ажиллагааны буюу сервер байршуулах, сервер түрээс, домэйн нэр, виртуаль сервер, ICS үйлчилгээний борлуулалтын орлого нэмэгдсэн ч хөгжүүлэлтийн ажил болон сургалтын менежментийн системийн борлуулалтын орлого хоцорч биелснээс үүдэн борлуулалт буурсан байна. 2021 оны эхний хагас жилд байгууллага, хувь хүмүүс эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг хүлээн, худалдан авалт өнгөрсөн жилүүдээс буурч байгаа нь илт мэдэгдэж байна.

Гэвч Засгийн газраас авч хэрэгжүүлсэн НДШ-ийн хөнгөлөлт гэх мэт арга хэмжээнүүдийн үр дүнд зарим нэг бүтээгдэхүүн үйлчилгээний өртгийг тодорхой хэмжээнд бууруулж, цэвэр ашгаа өнгөрсөн онуудтай харьцуулахад өсгөж ажиллажээ.




Борлуулалтын орлого, ББӨ, цэвэр ашгийн сүүлийн 3 жилийн харьцуулалт /мянган төгрөгөөр/



## ЦЭВЭР АШГИЙН МАРЖИН

2021 оны эхний хагас жилийн байдлаар цэвэр ашгийн маржин нь 7%-ийн үзүүлэлттэй байна. Энэ нь жилүүдийн мөн үеийнхтэй харьцуулахад өссөн үзүүлэлт болохыг та бүхэн графикаас харна уу.

Үзүүлэлт	2019 Q2	2020 Q2	2021 Q2
Цэвэр ашиг	42,907,697	22,834,512	62,971,805
Борлуулалтын орлого	1,098,392,545	1,401,043,015	924,104,631
<b>Цэвэр ашгийн маржин</b>	<b>4%</b>	<b>2%</b>	<b>7%</b>




## НИЙТ ХӨРӨНГИЙН БОЛОН ЭЗДИЙН ӨМЧИЙН ӨГӨӨЖ

2021 оны эхний хагас жилийн байдлаар цэвэр ашгийн өсөлтийн хувь нь нийт хөрөнгө болон эздийн өмчийн өсөлтийн хувиас өндөр байсан тул өмнөх онуудтай харьцуулахад эдгээр үзүүлэлтүүд нь өсөлттэй гарсан байна. Мөн 2021 онд урт хугацаат зээл авснаар санхүүгийн хөшүүргийн хувь хэмжээ нэмэгдсэнээр эздийн өмчийн өгөөж харьцангуй өндөр болж өссөн байна. Санхүүгийн хөшүүрэг 2020 оны эхний хагаст 1.09 байсан бол энэ оны эхний хагасын байдлаар 1.27 болж нэмэгдсэн байна. Эздийн өмчийн өгөөжид ДюПон анализ хийж үзэхэд санхүүгийн хөшүүрэг болон хүү болон татварын өмнөх ашиг нэмэгдсэн нь 1.79% болж өсөхөд нөлөөлжээ.

Үзүүлэлт	2019 Q2	2020 Q2	2021 Q2
Цэвэр ашиг	42,907,697	22,834,512	62,971,805
Нийт хөрөнгө	3,615,802,415	3,503,907,414	4,491,918,082
<b>ROA</b>	<b>1.19%</b>	<b>0.65%</b>	<b>1.40%</b>

Үзүүлэлт	2019 Q2	2020 Q2	2021 Q2
Цэвэр ашиг	42,907,697	22,834,512	62,971,805
Нийт эздийн өмч	3,036,459,051	3,222,416,623	3,525,319,868
<b>ROE</b>	<b>1.41%</b>	<b>0.71%</b>	<b>1.79%</b>



## НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ АЛДАГДАЛ, P/E ХАРЬЦАА БОЛОН ДАНСНЫ ҮНЭ

2021 оны эхний хагас жилийн байдлаарх P/E харьцаа болон Нэгж хувьцаанд ногдох ашгийн үзүүлэлтийг өмнөх жилүүдийн мөн үеийнхтэй харьцуулан хүснэгтээр харуулж байна. Эдгээр нь хагас жилийн үзүүлэлтүүд болохыг та бүхэн анзаарна уу. 2021 онд "Айтүүлс" ХК-ийн хувьцааны ханш тогтмол өсч 6 сарын 30-ны хаалтын ханш 119.26 хүрсэн байна. Бид 2021 онд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, дэд бүтэц, Дарханы дата төвийн ажлуудад шаардагдах хөрөнгө оруулалтуудыг хийн, 2021 онд Дархан дата төвийн угсралт суурилуулалт, үүлэн технологийн cloud.mn платформ болон сургалтын менежментийн системийн өргөтгөл, сайжруулалтын ажлыг дуусган ашиглалтанд оруулахаар ажиллаж байна.

Үзүүлэлт	2019Q2	2020Q2	2021Q2
Цэвэр ашиг	42,907,697	22,834,512	62,971,805
Хувьцааны тоо	34,452,124	34,452,124	34,452,124
<b>EPS</b>	<b>1.25</b>	<b>0.66</b>	<b>1.83</b>

Үзүүлэлт	2019Q2	2020Q2	2021Q2
EPS	1.25	0.66	1.83
Хаалтын ханш (6 сарын 30)	85	76	119.26
<b>P/E харьцаа</b>	<b>68.63</b>	<b>115.38</b>	<b>65.25</b>

Үзүүлэлт	2019Q2	2020Q2	2021Q2
Нийт хөрөнгө	3,615,802,415	3,503,907,414	4,491,918,082
Өр төлбөр	579,343,364	281,490,792	966,598,213
Гаргасан хувьцааны тоо	34,452,124	34,452,124	34,452,124
<b>ROE</b>	<b>88.14</b>	<b>93.53</b>	<b>102.33</b>

itools

